

“ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

Үндэслэл, тайлбар

Монгол Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр соёрхон баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэн “**Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага**”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Зөвшөөрлийн тухай” хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль хүчингүй болох юм.

Иймд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулиар зохицуулсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг “Зөвшөөрлийн тухай” хуульд нийцүүлэх шаардлагын үүднээс “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д дараах өөрчлөлтийг оруулахаар санал авч байна.

“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” нь Зохицуулах хорооны 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоолын хавсралтаар батлагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болно.

№	Одоогийн заалт	Өөрчлөлт оруулах санал
1	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, Өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримтлах бодлого, бодлогын чиглэлд нийцсэн байна.	1.2 Энэхүү нөхцөл, шаардлага нь Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Зөвшөөрлийн хууль , холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, Өргөн нэвтрүүлгийн талаар төрөөс баримтлах бодлого, бодлогын чиглэлд нийцсэн байна.
2	1.4 Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу нээлттэйгээр сонгон шалгаруулах ба Зохицуулах хорооноос баталсан "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам"-ыг баримтлана.	1.4 Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу нээлттэйгээр сонгон шалгаруулна.

3	<p>1.7 Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл, шаардлага болон Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-аар зохицуулна.</p>	<p>1.7 Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл, шаардлагаар зохицуулна.</p>
4	<p>2.4 Үйлчилгээний хамрах хүрээ, сүлжээ, технологийн төрөлд нэмэлт өөрчлөлт оруулахад "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ыг баримтлах ба ирүүлсэн хүсэлтийг үнэлэхэд радио давтамжийн нөөц, хуваарилалт, өрсөлдөөний нөхцөл байдал, хэрэглэгчид үзүүлэх үр өгөөж, технологийн дэвшил зэргийг харгалзан үзнэ.</p>	<p>2.4 Үйлчилгээний хамрах хүрээ, сүлжээ, технологийн төрөлд нэмэлт өөрчлөлт оруулахад өрсөлдөөний нөхцөл байдал, хэрэглэгчид үзүүлэх үр өгөөж, технологийн дэвшил зэргийг харгалзан үзнэ.</p>